



ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ
САЙДЫН ТУШААЛ

2012 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 078

Улаанбаатар хот


Журам батлах тухай

Монгол Улсын “Засгийн газрын тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, “Ашигт малтмалын тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


Нэг. “Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээ байгуулах журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны тухай гэрээний загвар”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Уурхайн ашиглалтын өмнөх үйл ажиллагааг энэхүү журмын дагуу зохион байгуулж, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ашигт малтмалын газар /М.Ариунбаяр/-т даалгасугай.

Гурав. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан “Журам батлах тухай” Ашигт малтмалын газрын даргын 2009 оны 410 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД  Д.ЗОРИГТ

Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын
2012 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн
078 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Зорилго

Энэхүү журмын зорилго нь Ашигт малтмалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах үүднээс хайгуулын ажлын явцад ашигт малтмалын орд тогтоогдож түүний нөөцийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэснээс хойш ордыг ашиглах зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, уурхай барьж байгуулах бэлтгэл ажлыг хангах, бүтээгдэхүүн гаргах хүртэлх хугацаанд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хоорондын харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Нийтлэг үндэслэл

2.1. Ашигт малтмалын тухай хуулийн 23 дугаар зүйлийг хэрэгжүүлэхэд геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын уул уурхайн асуудал хариуцсан нэгж болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хооронд уурхайн ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээ (цаашид гэрээ гэх)-г байгуулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

2.2. Энэхүү гэрээг Ашигт малтмалын тухай хууль, Иргэний хууль, холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журамд нийцүүлэн нэг талаас геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, нөгөө талаас Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцүүлж, ашигт малтмалын орд (цаашид орд гэх)-ын нөөцийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулна.

2.3. Гэрээг Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын тушаалаар баталсан "Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээний загвар"-ын дагуу байгуулна.

Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

3.1. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч Эрдэс, баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцүүлж, ашигт малтмалын орд (цаашид орд гэх)-ын нөөцийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлснээс хойш Ашигт малтмалын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан үндэслэлээр гэрээ байгуулах тухай хүсэлтийг албан бичгээр геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

3.2. Энэхүү журмын 3.1-д заасан гэрээ байгуулах хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:

3.2.1.Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэж, нөөцийг улсын бүртгэлд бүртгэсэн тухай Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, Ашигт малтмалын газрын даргын шийдвэр;

3.2.2.Техник, эдийн засгийн урьдчилсан үнэлгээ /Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд танилцуулсан/;

3.2.3.Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын тушаалаар баталсан гэрээний загварын дагуу байгуулах гэрээний төсөл;

3.2.4.Аж ахуйн нэгжийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;

3.2.5.Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн нотариатаар баталгаажуулсан хуулбар;

3.2.6.Нөөцийн дэвсгэр зураг дээр тусгай зөвшөөрлөөр олгосон талбайг буулгасан дэвсгэр зураг, тухайн талбайд бодсон нөөцийн тооцоо; /Итгэмжлэгдсэн байгууллагаар/

Дөрөв. Ашигт малтмалын газрын эрх, үүрэг

4.1.Энэхүү журмын 3.2-т заасан баримт бичгийн бүрдлийг үндэслэн ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээний хугацааг Ашигт малтмалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасан хугацааны дотор ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй зөвшилцөн тодорхойлж гэрээнд тусгах үүрэг хүлээнэ.

4.2.Ашигт малтмалын газрын уул уурхайн асуудал хариуцсан нэгж нь ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрээ байгуулах албан хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор гэрээний нөхцөлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хэлэлцэн тохиролцож гэрээ байгуулна.

4.3.Энэ журмын 4.2-т заасан хугацаанд Ашигт малтмалын газрын уул уурхайн асуудал хариуцсан нэгж нь хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээний нөхцөл дээр тохиролцоонд хүрээгүй тохиолдолд энэ тухайгаа албан бичгээр мэдэгдэнэ.

Тав. Гэрээний хэрэгжилт, түүнийг дүгнэх

5.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээний хэрэгжилтийн тайланг гэрээнд заасан хугацааны дотор Ашигт малтмалын газарт хүргүүлэх бөгөөд ийнхүү ирүүлэхдээ Иргэний хуулийн 72 дугаар зүйлд заасан хугацаа тоолох журмыг баримтална.

5.2.Ашигт малтмалын газар гэрээний хэрэгжилтийн тайланг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран дүгнэнэ.

5.3.Гэрээ байгуулагч аль нэг талын хүсэлтийг үндэслэн гэрээг 1 /нэг/ удаа сунгаж болох ба ийнхүү сунгах хугацаа нь анхны гэрээний хугацааны хамт Ашигт малтмалын тухай хуулийн 23.2 дахь хэсэгт заасан хугацаанаас илүүгүй байна.

5.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээний заалтыг зөрчсөн бол уг зөрчил илэрснээс хойш, тайланд гэрээний заалт бүрийн хэрэгжилтийг тодорхой тусгаагүй тохиолдолд Ашигт малтмалын газар нь тайланг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор гэрээний заалтыг зөрчсөн шалтгаан, эсхүл гэрээний заалт бүрийн хэрэгжилтийг тайланд тусгаагүй шалтгааны талаар нэмэлт тайлбар тухай тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр мэдэгдэнэ.

Зургаа. Хариуцлага

6.1.Дараах тохиолдолд гэрээг цуцлах, дуусгавар болгох үндэслэл болно.
Үүнд:

6.1.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээний биелэлтийг энэхүү журмын 5.1-д заасан хугацаанд Ашигт малтмалын газарт хүргүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах үндэслэл болно.

6.1.2.Гэрээний хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас өмнө гэрээлэгч талуудын аль нэг нь гэрээг гэрээнд заасан үндэслэлээр цуцлах хүсэлтээ бичгээр гаргасан бол гэрээг цуцлах үндэслэл болно.

6.1.3.Гэрээний үйлчлэх хугацаа Ашигт малтмалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасан хугацаанаас хэтэрсэн тохиолдолд гэрээний үйлчлэх хугацаа дуусгавар болсонд тооцно.

6.1.4.Талууд гэрээний хэрэгжилтийг хамтран дүгнэж акт үйлдсэнээр гэрээг дуусгавар болсонд тооцно.

6.1.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь тогтоогдсон, гэрээний зүйл, заалтыг зөрчсөн, мэдээ тайланг хуурамчаар үйлдсэн тохиолдолд Ашигт малтмалын газар ашиглалтын өмнөх үйл ажиллагааг дуусгавар болгож, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---- оОо ----

Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын
2012 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн
07.8 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны тухай
ГЭРЭЭ №АӨҮА-20 ... / ...

Ерөнхий зүйл

Ашигт малтмалын тухай хуулийн 23 дугаар зүйлийг үндэслэн нэг талаас Ашигт малтмалын газар (цаашид АМГ гэнэ), нөгөө талаас тоот хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аймаг (хот)-ын сум (дүүрэг)-ын Татварын албанд бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоот гэрчилгээ, регистрийн дугаартай компани (цаашид компани гэнэ) нь Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 20 ... оны ... дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээ байгуулах журмыг үндэслэн аймаг (хот)-ийн сум (дүүрэг)-ын нутагт орших -ын ордын ашиглалтын өмнөх үйл ажиллагааны үед хийгдэх үндсэн ажлуудын хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх үе шат, хүлээх хариуцлагыг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний нөхцөл, хугацаа

1. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны үе шатанд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- а. Ордыг ашиглах зураг төсөл
- б. Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах
- в. Уурхай барьж байгуулах
- г. Бүтээгдэхүүн гаргах

2. Орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг 20... оны ... дугаар сарын ... -ны дотор АМГ-т ирүүлнэ.

3. Ордын технологийн туршилтын хугацаа ... хоног байна.

4. Орд ашиглах төслийн хүчин чадалд хүрэх хугацаа ... хоног байна.

5. аймаг (хот) ийн сум (дүүрэг) ын нутагт орших ын ордын ашиглалтын өмнөх үйл ажиллагааг 20... оны ... дугаар сарын ... -нд дуусгавар болгоно.

Хоёр. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх эрх, үүрэг

1. Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн эрэл, эрэл-үнэлгээ, хайгуулын ажлын зардлыг улсын төсөвт нөхөн төлөх гэрээг орд ашиглах техник, эдийн засгийн

үндэслэл боловсруулахаас өмнө Засгийн газрын 2007 оны 81 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу байгуулсан байна.

2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын өмнөх үйл ажиллагааны үе шатанд ашиглалтын үед хийж гүйцэтгэх дараах ажлын зөвшөөрлийг авсан байна. Үүнд:

- а.
- б.
- в.

3.Ордыг ашиглах, эрдсийг баяжуулах, боловсруулах үед хэрэглэгдэх химийн бодис ашиглах зөвшөөрлийг авсан байна. Үүнд:

- а.
- б.
- в.

4.Гэрээний биелэлтийн тайланг гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш (хоног, сар, жил) тутам АМГ-т ирүүлнэ.

5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээний биелэлттэй холбоотойгоор АМГ-аас үзлэг, шалгалт хийж байгаа төлөөлөгчдөд холбогдох баримт, бичгүүдтэй танилцах боломж олгон, үйлдвэрлэлийн талбайд саадгүй нэвтрүүлнэ.

7.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээний заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хүсэлтээ АМГ-т бичгээр гаргаж болно.

8.Орд ашиглахтай холбогдсон бичиг баримтыг Монгол хэл дээр үйлдсэн байна.

9.Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны үе шатанд гарч байгаа зардлуудыг татварын албанд тушаасан тухай мэдэгдлийг тайланд тусгасан байна.

10.Энэхүү гэрээг гэрээнд заасан нөхцөлөөс өөр хэлбэрээр ашиглахыг хориглоно.

Гурав. Ашигт малтмалын газрын эрх, үүрэг

1.Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гэрээний биелэлтийн талаар болон ашиглалтын өмнөх үйл ажиллагааны явцын тухай мэдээлэл авах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд энэ тухай бичгээр хүргүүлнэ.

2.Энэхүү гэрээний заалтуудад өөрчлөлт оруулах тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн саналыг авсан байна.

3.Гэрээний заалтуудын биелэлтэд үзлэг, шалгалт хийх хүсэлтээ бичгээр хүргүүлнэ.

4.Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гэрээний заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хариуг бичгээр хүргүүлнэ.

Дөрөв. Бусад зүйл

1.Энэхүү гэрээнд АМГ болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөөлөгчид гарын үсэг зурсан өдрөөс хойш хүчин төгөлдөр болно.

2.Энэхүү гэрээний биелэлтийг ордыг ашиглалтад хүлээн авсан комиссын дүгнэлт, шийдвэр (гэрээний заалтууд бүрэн биелсэн акт)-ийг үндэслэн гэрээлэгч талууд хамтран дүгнэж акт үйлдэнэ.

3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гарах үр дагаврыг бүрэн хариуцна.

4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээний биелэлтийг АМГ-тай хамтран дүгнээгүй тохиолдолд ашигт малтмалын тоот тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг хориглоно.

5.Гэрээг 3 /гурав/ хувь үйлдсэн бөгөөд 1 /нэг/ хувийг АМГ-ын уул уурхай /нүүрсний/-н асуудал хариуцсан нэгжид, 1 /нэг/ хувийг тусгай зөвшөөрөл эзэмшигч, 1 /нэг/ хувийг кадастрын бүртгэлийн төвийн архивт тус тус хадгална.

6.Энэхүү гэрээний биелэлттэй холбогдон гарах маргааныг гэрээлэгч талууд харилцан тохирч шийдэх бөгөөд эс шийдэлд хүрсэн тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Гэрээ байгуулсан:

Ашигт малтмалын газрыг төлөөлж:
Уул уурхайн /нүүрсний/ асуудал
хариуцсан төрийн захиргааны
байгууллагын нэгжийн дарга:

..... (Гарын үсэг)

(Тамга)

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг
төлөөлж:

..... ХХК-ийн захирал
..... (Гарын үсэг)

(Тамга)

Улаанбаатар хот

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

---- оОо ----